



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/182

Хэрлэн сум

Цэрэг-спортын “ДӨЛ” тэмцээн
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1 Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.10 Батлан хамгаалахын сайдын Хэнтий аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээний 1.7 дахь заалт, Батлан хамгаалахын сайдын 2022 оны А/50 дугаар тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Хүүхэд залуучуудад цэрэг-эх орсонч үзэл төлөвшүүлэх, бие бялдрын болон ёс суртахуун, сэтгэл зүйн хүмүүжил олгох, эх орноо батлан хамгаалах бэлтгэл эзэмшүүлэх зорилгоор аймгийн аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг 2 үе шаттайгаар зохион байгуулсугай.

2. Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээний бэлтгэлийг хангах, зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, тэмцээний удирдамжийг хоёрдугаар, тэмцээний хуваарийг гуравдугаар хавсралтаар баталсугай.


3. Тэмцээний нэгдүгээр шатанд батлагдсан удирдамжийн дагуу ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдыг бүрэн хамруулж, сургуулийн аварга тасаг шалгаруулах, хоёрдугаар шатанд сургууль бүрээс шалгарсан 1 тасгийг бэлтгэлийг ханган, аюулгүй ажиллагааны заавар, бусад холбогдох дүрэм, журмыг сайтар мөрдүүлж, аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцуулахыг сумын Засаг дарга, ерөнхий боловсролын сургуулийн Захирал нарт үүрэг болгосугай.

4. Тэмцээний бэлтгэл болон зохион байгуулах үеийн арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө гарган, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулж дүнг илтгэхийг ажлын хэсэг (хурандаа Н.Хүрэлээ)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2022 оны
дугаар сарын 06-ны өдрийн
захирамжийн нэгдүгээр хавсралт

**ЦЭРЭГ-СПОРТЫН “ДӨЛ” ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНИЙГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ**

Ажлын хэсгийн дарга:	Н.Хүрэлээ	Цэргийн штабын дарга, хурандаа
Гишүүд:	Д.Өнөрцэцэг	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
	Н.Мягмарцоож	Зэвсэгт хүчний 232 дугаар ангийн захирагч, хурандаа
	С.Мөнхцэцэг	Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга
	Л.Мэндбаяр	Эрүүл мэндийн газрын дарга
	Г.Нэргүйбаатар	Биеийн тамир, спортын газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Ц.Батсайхан	Монгол цэргийн нэгдсэн холбооны Хэнтий аймаг дахь салбар холбооны Нарийн бичгийн дарга
	А.Сарантуяа	Батлан хамгаалах туслах нийгэмлэгийн Хэнтий аймаг дахь зөвлөлийн дарга
	С.Галбадрах	Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалт, сургалтын офицер, хошууч

Аймгийн Засаг даргын 2022 оны
04 дугаар сарын 06-ны өдрийн
А/182 захирамжийн хоёрдугаар хавсралт

**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ
АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ЦЭРЭГ-СПОРТЫН "ДӨЛ"
ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

Нэг. Тэмцээний зорилго:

Хэнтий аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад цэрэг-эх оронч хүмүүжил олгон, эх орон, эх хэл, түүх, соёл, уламжлал, ёс заншлаараа бахархах үзлийг төлөвшүүлэх, тэдэнд бие бялдрын болон сэтгэл зүйн бэлтгэл, тэсвэр хатуужил суулгаж, эх орноо батлан хамгаалах залгамж халааг бэлтгэхэд оршино.

Хоёр. Тэмцээн явуулах хугацаа, байрлал:

2.1.Аймгийн Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах Цэрэг-спортын "Дөл" цогцолбор тэмцээнийг дараах 2 үе шаттайгаар явуулна.

2.1.1.нэгдүгээр үе шат: Аймгийн 12 жилийн сургалттай ерөнхий боловсролын сургуулиуд 2022 оны 4 дүгээр сарын 30-ны дотор багтаан тэмцээнийг удирдамжийн дагуу зохион байгуулж, сургууль тус бүр нэг тасгийг шалгаруулан аймгийн аварга шалгаруулах тэмцээнд өрсөлдүүлнэ.

2.1.2.хоёрдугаар үе шат: Чингис хотод 5 дугаар сарын 28-ны өдрөөс 29-ний өдрийн хооронд тэмцээнийг зохион байгуулж явуулна.

Гурав. Тэмцээний ерөнхий зохион байгуулалт:

3.1.Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб, Боловсрол, шинжлэх ухааны газар, Биеийн тамир, спортын газар, Нэгдсэн эмнэлэг, Зэвсэгт хүчний 232 дугаар ангийн төлөөлөл бүхий ажлын хэсэг батлагдсан удирдамжийн дагуу тэмцээнийг зохион байгуулж, дүнг нэгтгэн гаргана.

3.2.Тэмцээний нэгдүгээр шатанд 12 жилийн сургалттай ерөнхий боловсролын сургуулиас шалгарсан тус бүр нэг тасаг хоёрдугаар шатанд аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцоно.

3.3.Тасаг нь тухайн аймгийн харьяалал бүхий ахлах ангийн 16-17 насны 11 (7 эрэгтэй, 4 эмэгтэй) гишүүнтэй байх бөгөөд нөөц эрэгтэй-1, эмэгтэй-1 гишүүнтэй байна. Тасгийн бүрэлдэхүүн ижил өнгө, загварын хувцас, хувцасны загварт тохирсон гуталтай, анхан шатны тусламжийн цүнхтэй байна. Эмнэлгийн анхан

шатны тусламжийн цүнхэнд дараах эм, эмнэлгийн хэрэгсэл байна. Үүнд:

- 3.3.1.хуруу лент 100 ширхэг,
- 3.3.2.ариун наалт 10 ширхэг,
- 3.3.3.йодтой савх 10 ширхэг,
- 3.3.4.спирттэй арчдас 10 ширхэг,
- 3.3.5.өвчин намдаах тос 1 ширхэг (диклоденк 2%-5 гр),
- 3.3.6.өвчин намдаах эм 1 ширхэг (диклоденк 50 мг),
- 3.3.7.уян боолт хэмжээ тус бүрээс 3 ширхэг,
- 3.3.8.мөчдийн уян чиг 2 ширхэг,
- 3.3.9.цус тогтоох чангалуур 2 ширхэг (хугацаа тавигчтай),
- 3.3.10.тэмдэглэлийн дэвтэр, бал 1 ком (жижиг),
- 3.3.11.гялгар уут (бахардсан тохиолдолд үлээлгэх зориулалттай),
- 3.3.12.амны хаалт, үзлэгийн бээлий тус бүр 10 ширхэг,
- 3.3.13.гар ариутгагч 1 ширхэг (жижиг).

3.4.Аймгийн аварга шалгаруулах тэмцээнд (цаашид “Тэмцээнд” гэх) оролцох тасгийг сумын Засаг даргын Тамгын газар, Сургуулийн захиргаа хариуцан оролцуулах ба тасаг бүр дасгалжуулагч-багш (ЕБС-ийн Биеийн тамирын)-тай байна.

3.5.Тэмцээнд оролцох тасгийн бүрэлдэхүүнийг харьяа орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулж, аймгийн нэгдсэн эмнэлгийн эрүүл мэндийн төвийн ерөнхий эмчийн дүгнэлт гаргуулж, гэнэтийн ослын даатгалд заавал даатгуулсан байна. Тэмцээний явцад томилогдсон эмнэлгийн эмч, эмнэлгийн ажилтнууд тэмцээнд оролцогчдын эрүүл мэндийн байдалд хяналт тавина.

3.6.Тасгийн гишүүд өөрийн сумын онцлогийг тусгасан 8 см голч бүхий ялгах тэмдгийг зүүн энгэртээ зүүсэн байна. Тасгийн чиглүүлэгч нь 40х40 см-ийн хэмжээтэй тасгийнхаа онцлогийг илэрхийлсэн дарцагтай байна.

3.7.Хоёрдугаар шатны аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах техникийн зөвлөгөөнийг тэмцээн эхлэхээс 1 хоногийн өмнө аймгийн Засаг даргын Тамгын газрын иргэний танхимд зохион байгуулна. Тэмцээнд ирэхдээ тэмцээнд оролцогчдын мэдүүлэг (мэдүүлэг цээж зурагтай байна)-ийг тодорхой бичиж, иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээний хуулбар, сурагчийн үнэмлэхний хуулбар зэргийн авчирна.

3.8.Тасаг бүр сумын туг, далбаатайгаар тэмцээний нээлт, хаалтын ажиллагаанд зохион байгуулалттай оролцоно. Туг, далбааны хэмжээ 2.0х1.0

метрийн хэмжээтэй байна.

3.9.Сумаас аймгийн төвд хүрэлцэн ирэх, буцах унаа, тээвэрлэлт, холбогдох бусад зардлыг тухайн сумын Засаг даргын Тамгын газар хариуцна.

3.10.Орон нутагт тэмцээний бэлтгэл хангах, тэмцээн зохион байгуулах газар ирэх, буцах болон бүх төрлийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангуулах ажлыг тухайн сумын Засаг даргын Тамгын газар хариуцаж, холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулна.

3.11.Хэнтий аймгийн Засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг явуулахад дараах дасгал, нормативуудыг хийж гүйцэтгэнэ.

Дөрөв. Гарааны өмнөх ажиллагаа

Тэмцээнд оролцох тасаг нь гарааны өмнө шүүгчээс өгөгдсөн даалгавар, дасгал, нормативыг тогтоосон байр, талбайд бүрэн бүрэлдэхүүнээрээ биелүүлнэ. Тасгийн захирагч нарын тэмцээнд туслах гишүүн оролцож болно.

Тасгууд гарааны өмнө жагсаалын үзүүлэх тоглолт, гардан тулааны үзүүлэх тоглолтыг тасгаараа хийж гүйцэтгэнэ. Тасгийн захирагч нарын дунд зохион байгуулах тэмцээнд Тасгийн захирагч, багийн эрэгтэй-1, эмэгтэй-1 нийт 3 гишүүн оролцоно. Галын бэлтгэлийн норматив зэргийг хийж гүйцэтгэнэ.

А. “Жагсаалын үзүүлэх тоглолт”:

Жагсаалтын үзүүлэх тоглолтод дараах үзүүлэлтүүд багтана. Жагсаалын үзүүлэх тоглолтын үргэлжлэх хугацаа 6-7 минут байна.

1. Зэвсэггүй жагсах үеийн жагсаалын ажиллагаа, хөдөлгөөн;
2. Ёсолж хүндэтгэх, жагсаалаас гарах, жагсаалд орох, захирагч /даргад очих, илтгэх, буцах ажиллагаа;
3. Тасгийн жагсаалын жигдрэлт;
4. Жагсаал удирдах дохио;
5. Жагсаалын дуу.

Тасаг бүр Цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээний сүлд дуу (Хөгжим Т.Мөнхтунгалаг, Шүлэг Г.Ганбат)-г заавал сурсан байхаас гадна, тасгийн захирагч доорх 10 жагсаалын дуунаас 1 жагсаалын дууг сугалж, дууг тасгийн бүрэлдэхүүн дуулна. Үүнд:

1. “Манай цэргийн жавхаа” Хөгжим Ш.Гунаажав, Шүлэг Б.Жалбуу
2. “Монгол Улсын төлөө зүтгэе” Хөгжим Б.Нямдорж, Шүлэг Г.Пүрэвдорж
3. “Энхийн үйлсэд Монгол цэрэг” Хөгжим Т.Насанбуян, Шүлэг Г.Баатарнум

4. “Дэлхийд данстай Монгол цэрэг” Хөгжим О.Эрдэнэцог, Шүлэг Г.Ганбат
5. “Баярын жагсаал” Хөгжим Г.Ганбат, Шүлэг Г.Ганбат
6. “Торгон хилийн зүг” Хөгжим Т.Чимэддорж, Шүлэг Ш.Сүрэнжав
7. “Цэргийн тухай дуу” Хөгжим Д.Дашням, Шүлэг С.Дашдооров
8. “Жанжин тугийн намираа” Хөгжим Т.Мөнхтунгалаг, Шүлэг Т.Бат-Очир
9. “Түүхт хил” Хөгжим Л.Мөрдорж, Шүлэг З.Пунцаг
10. “Улаан туг” Ардын журамт цэргийн дуу

Үнэлэлт:

Жагсаалын үзүүлэх тоглолтын дүнг гаргахдаа Тасгийн захирагчийн жагсаал удирдах ур чадвар, жагсаалын элементийн гүйцэтгэл, тасгийн жигдрэлт, сургагдсан байдлыг тооцон үзүүлэлт тус бүрд 5 минут хүртэл шагнал өгнө. Үнэлгээг үндсэн 5 үзүүлэлтийн нийлбэрийн дунджаар бодож хугацааны шагнал өгнө. Жагсаалын явц дахь алдаа бүрд 20 секундийн торгууль онооно.

Б.”Гардан тулааны үзүүлэх тоглолт”,

Гардан тулааны үзүүлэх тоглолтод дараах үзүүлэлтүүд багтана. Гардан тулааны үзүүлэх тоглолтын үргэлжлэх хугацаа 6-7 минут байна.

1. Зэвсэггүй гардан тулааны хөдөлгөөн, ката-нууд;
2. Зэвсэгтэй гардан тулааны дасгал, хөдөлгөөн, ката-нууд;
3. Гарын цохилт, хөлийн өшиглөлтийн техникийн үзүүлэлтүүд;
4. Итгэл үнэмшил, зохиомж.

Үнэлэлт:

Гардан тулааны үзүүлэх тоглолтын дүнг гаргахдаа Тасгийн захирагчийн удирдах ур чадвар, дасгалын гүйцэтгэл, тасгийн жигдрэлт, сургагдсан байдлыг тооцон үзүүлэлт 5 минут хүртэл шагнал өгнө. Үнэлгээг үндсэн 4 үзүүлэлтийн нийлбэрийн дунджаар бодож хугацааны шагнал өгнө. Үзүүлэх тоглолтын явц дахь алдаа бүрд 20 секундийн торгууль онооно. Өөрийгөө гэмтээх, шарх авах тохиолдол тус бүрд 2 минутын торгууль онооно.

В.”Нормативын бэлтгэл”:

Тасгийн захирагч нар биеийн тамирын болон галын бэлтгэлийн норматив, тасгийн бүрэлдэхүүнээс үй олноор хөнөөх зэвсгээс хамгаалах бэлтгэлийн тус бүр нэг дасгал, нормативыг сугалаагаар биелүүлнэ.

Биеийн тамирын ЦБТЗ-18 зааврын 19 дүгээр дасгал (гар дээр тулан хэвтэж суниах), ЦБТЗ-18 зааврын 7 дугаар дасгал (дүүжинд суниах), ЦБТЗ-18 зааврын 20 дугаар дасгал (гэдэсний таталт), галын бэлтгэлийн 12 дугаар норматив (Автоматын хагас задаргаа), 13 дугаар норматив (Автоматыг угсрах) 15 дугаар норматив

(Магазиныг цэнэглэх)-ыг биелүүлнэ.

Тасгийн бүрэлдэхүүнээс 1 эрэгтэй, 1 эмэгтэй гишүүн үй олноор хөнөөх зэвсгээс хамгаалах бэлтгэлийн 36 дугаар норматив (Ерөнхий цэргийн хамгаалалтын иж, газ эсэргүүцэгч өмсөх)-ыг сугалаагаар сонгон гүйцэтгэнэ.

Үнэлэлт:

Дасгал, нормативын гүйцэтгэл тус бүрд “онц” биелүүлбэл 1 минут, “сайн” биелүүлбэл 40 секунд, “дунд” биелүүлбэл 20 секундийн шагнал, “муу” үнэлгээ авбал 1 минутын торгууль онооно.

Д.Галын бэлтгэлийн норматив:

Тасаг галын бэлтгэлийн талбайд сугалааны дарааллаар ирж галын бэлтгэлийн 12 дугаар норматив (Автоматын хагас задаргаа), 13 дугаар норматив (Автоматыг угсрах), 15 дугаар норматив (Магазиныг цэнэглэх)-ыг гүйцэтгэнэ. Нормативын үнэлгээг тасгийн бүх гишүүдийн хүн нэг бүрийн үнэлгээгээр тооцож гаргана.

Үнэлэлт:

Нормативын гүйцэтгэл тус бүрд “онц” биелүүлбэл 1 минут, “сайн” биелүүлбэл 40 секунд, “дунд” биелүүлбэл 20 секундийн шагнал өгч, “муу” үнэлгээ авбал 1 минутын торгууль онооно.

Тав. “Марш, гүйлтийн замд гүйцэтгэх ажиллагаа”:

Тасгууд сугалааны дарааллаар 15 минутын зайтайгаар гараанаас гарч 6 км замыг туулж, гүйлтийн явцад 7 цэг дээр өгөгдсөн дасгалыг гүйцэтгэнэ. Марш, гүйлтийн тэмцээний явцад гүйцэтгэх дасгалын цэг дээр тасгууд давхар ирсэн тохиолдолд цэгийн шүүгч нар эхний тасгийг цэгээс гарах хүртэл дараагийн тасгийн цагийг зогсоож, хугацааг тухайн тасгийн гүйлтийн цэвэр цагаас хасаж тооцно.

Гарааны өмнө тасгийн бүрэлдэхүүний иргэний үнэмлэх, сурагчийн үнэмлэх, хувцас хэрэглэл, анхан шатны тусламжийн цүнх, гэнэтийн ослын даатгалын баримт бичиг зэрэгт үзлэг явуулна. Илэрсэн зөрчил бүрд 30 секундийн торгууль онооно.

Нэгдүгээр дасгал: Гранат шидэлт”:

Тасаг гараанаас гарч хоёрын цуваагаар гранат шидэлтийн талбайд очиж дараах дасгалыг боловсруулна. Үүнд:

-эрэгтэй гишүүд 25 метр холд байрлах 1, 3, 5 метрийн диаметр бүхий онооны тойрогт 600 гр жинтэй сургуулийн Ф1 гар гранатыг ил газраас, босоо байдлаас;

-эмэгтэй гишүүд 10 метр өргөн, 20 метр холын тэмдэглэгээ бүхий зурваст 600 гр жинтэй сургуулийн Ф1 гар гранатыг холд ил газраас, босоо байдлаас шиднэ.

Үнэлэлт:

Гранатыг 1 метрийн диаметртэй тойрогт оновол 1 минут, 3 метрийн тойрогт оновол 40 секунд, 5 метрийн тойрогт оновол 20 секундийн шагнал, холд 20 метрээс цааш шидвэл 1 минут шагнал өгнө.

Тойргийн гадна, 20 метрээс дотогш буюу зурвас (10 м-ийн коридор)-ын гадна шидсэн гранат тус бүрд 1 минутын торгууль онооно.

Хоёрдугаар дасгал: "Саадын зурвас":

Тасаг цааш хөдөлгөөнийг үргэлжлүүлэн "Саадын зурвас"-ыг хэсэгчилэн дараах байдлаар туулна.

1 эгнээ зиг заг хэлбэрээр тавьсан дугуйн голоор хөлөө хийж тасгаар гүйж гарна. 50см-ийн өндөртэй 15м урт бүхий торон саадийг мөлхөлтөөр туулна. Торон саадыг гарсны дараа хүн бүр гранат шидэх талбайд ирж 15м хол зайд байрлуулсан дугуйнд 600гр гранатыг шиднэ.

2 Үнэлэлт:

Саадын зурвасын аль нэг элементийг туулж чадаагүй тойрч гарсан тохиолдол тус бүрд 30 секундийн торгууль онооно. 15м-ийн зайнд байх дугуйг оносон гранат бүрт 1 минутын шагналтай, оноогүй гранат бүрд 30 секундын торгууль онооно.

Гуравдугаар дасгал: "Буудлагын дасгал":

Тасгийн бие бүрэлдэхүүн буудлагын талбайд очиж, /хийн/ буугаар цель /шаар, шил г.м./-ийг 10-15 метрт буудаж устгана.

Үнэлэлт:

Устгагдсан цель бүрд 1 минутын шагнал өгч, устгагдаагүй цель бүрд 30 секундийн торгууль онооно.

Дөрөвдүгээр дасгал: "Тактикийн ажиллагаа":

Тасаг шүүгчийн тогтоосон заагаас дохиогоор гинжинд тарна. Гинжинд тарсан үед хүн бүрийн хоорондын завсар "Байлдааны дүрэм"-д заасны дагуу /6-8 м буюу 10-12 алхам/ байна.

Тэмдэглэсэн заагт ирмэгц цөмийн дэлбэрэлтийн гялсхийлтээр ажиллаж, Тасгийн захирагчийн командаар 2 жигүүрээс 50 м-ийн үсрэлттэйгээр давшиж, 25 м торон саадыг мөлхөлтөөр туулан харилцах шуудууны баруун талд байгаа дарцгийг тойрч цаашид гүйлтээ үргэлжлүүлнэ. Тактикийн ажиллагааг Тасгийн захирагчийн ажиллагаа, заагуудад хүч задлах, байлдааны талбарт хөдөлгөөн үйлдэх ажиллагаа гэсэн үзүүлэлтүүдээр дүгнэнэ.

Үнэлэлт:

Үзүүлэлт бүрд 3 минут хүртэл шагнал өгч, нийлбэрийн дунджаар шагнал болон

торгууль онооно.

Тавдугаар дасгал: “Эмнэлгийн норматив”:

Тасгийн эмнэлгийн зааварлагч, шүүгчийн томилсон тасгийн нэг гишүүнтэй хамт шархтанд эмнэлгийн анхан шатны тусламжийг үзүүлж, Цэргийн хүн эмнэлгийн бэлтгэлийн 3 дугаар норматив (цус гоожилтыг тогтоогч резин чангалуурыг гуянд тавих), 5 дугаар норматив (биеийн дээд болон төгсгөл хэсгийн яс хугарах үед гарын доорх материалаар чиг тавих)-ыг гүйцэтгэн шархтныг аюулгүй зайд татан гаргаж, Эмнэлгийн байранд хүргэнэ.

Үнэлэлт:

Гүйцэтгэсэн норматив (эмнэлэг)-ын “онц” гүйцэтгэвэл 1 минут, “сайн” гүйцэтгэвэл 30 секунд, “дунд” гүйцэтгэвэл 10 секундын шагнал өгч, “муу” үнэлгээ авбал 1 минутын торгууль онооно.

Зургаадугаар дасгал: “Цэргийн байр зүйн норматив”:

Тасаг газар орон дээр азимутаар хөдөлгөөн үйлдэж, урьдчилан бэлтгэсэн 2 цэгийг GPS-ийн тусламжтайгаар цэг олох нормативыг тасгийн зохион байгуулалтаар 4 хүртэлх минутын хугацаанд биелүүлнэ.

Үнэлэлт:

Хоёр цэгийг олбол 2 минутын шагнал, 1 цэгийг олбол 1 минутын шагнал өгч, 1 цэгийг олоогүй тохиолдолд 30 секундын торгууль, 2 цэг олоогүй тохиолдолд 2 минутын торгууль онооно.

Долоодугаар дасгал: “Химийн норматив”:

Тасаг тэмдэглэсэн заагт ирмэгц шүүгчийн дохиогоор Үй олноор хөнөөх зэвсгээс хамгаалах бэлтгэлийн 1 дүгээр норматив (газ эсэргүүцэгч өмсөх)-ыг биелүүлэн 100 м хордсон газар орныг газ эсэргүүцэгч багтайгаа туулна.

Үнэлэлт:

1 дүгээр норматив: Тасгаараа “онц” биелүүлбэл 3 минут, “сайн” биелүүлбэл 2 минут, “дунд” биелүүлбэл 1 минутыг шагнал өгнө. “Муу” үнэлгээ авсан тохиолдолд 3 минутын торгууль оноож, үнэлэлт бууруулах алдаа гаргасан хүн бүрийг 20 секундээр торгоно.

Тасгийн бүрэлдэхүүн газ эсэргүүцэгч багийг уутанд хийж, цааш хөдөлгөөнөө үргэлжлүүлэн барианд зохион байгуулалттайгаар орно.

Бариланы цагийг тасгийн сүүлийн гишүүнээр тооцно. Бариланд хүн дутуу орох, тасгийн 11 хүнээс гадна өөр хүн дагаж бариланд орвол 5 минутын торгууль онооно. Тасгуудыг маршид гүйсэн цэвэр цагаар нь тооцон эхний 4 байр эзлүүлнэ.

Үнэлэлт:

1 дүгээр байрт 5 минут, 2 дугаар байрт 4 минут, 3 дугаар байрт 3 минут, 4 дүгээр байрт 2 минутын шагналыг тус тус өгч, тасгийн ерөнхий дүнд оруулан тооцно.

Зургаа. Тэмцээнийг үнэлэх журам:

6.1.Тэмцээний явцад биелүүлэх дасгал, нормативыг дараах баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт, үнэлэх журмын дагуу үнэлнэ. Үүнд:

6.1.1.цогцолбор тэмцээний заавар (хавсрагдсан);

6.1.2.цэргийн биеийн тамирын заавар, ЗХЖШ, ЦБТЗ-2018 он;

6.1.3.цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт, ЗХЖШ, 2017 он.

Долоо. Дүн гаргах, шагнал урамшуулал олгох:

7.2.Тэмцээний дүнг гаргахдаа тасгийн гүйлтийн цэвэр цагаас шагналын хугацааг хасаж, торгуулийн хугацааг нэмэх журмаар хамгийн бага цагаар байр эзлүүлнэ.

7.3.Шагналт (I, II, III) болон тусгай (IV) байр эзэлсэн тасгийн бүрэлдэхүүнд дараах шагнал урамшуулал олгоно. Үүнд:

7.3.1.нэгдүгээр шатны шалгаруулалтын шагнал урамшууллыг сумын Засаг даргын Тамгын газар хариуцана.

7.3.2.хоёрдугаар шатны шалгаруулалтад тэргүүн байр эзэлсэн тасгийн бүрэлдэхүүнийг “Аймгийн Засаг даргын нэрэмжит шилжин явах цом”, “Алтан медаль”, “Өргөмжлөл”;

7.3.3.дэд байр эзэлсэн тасгийн бүрэлдэхүүнийг “Мөнгөн медаль”, “Өргөмжлөл”;

7.3.4.гутгаар эзэлсэн тасгийн бүрэлдэхүүнийг “Хүрэл медаль”, “Өргөмжлөл”;

7.3.5.тусгай байр эзэлсэн 1 тасгийн бүрэлдэхүүнийг “Өргөмжлөл”, мөнгөн шагналаар шагнаана.

7.4.Тэмцээнд тамирчдаа амжилттай бэлтгэн оролцуулж, шагналт байранд шалгаруулсан сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга, Сургуулийн захирал нарыг “Медаль”, “Өргөмжлөл”-өөр шагнаана.